

**ӨВ. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,  
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭ  
/2019 оны 4 дүгээр улирал/**

2019.12.12

Өвт

№	Ажлын чиглэл	Үзүүлэлт	Сум, байгууллага /тоон үзүүлэлт/	
1	Хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо	12122	
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо	385	
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл, заалтын тоо	10/65	
		Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	268
			Байгууллага	9
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	45
Байгууллага	6			
2	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж /гарсан захирамж/	Нийт 165 захирамж	
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүйн яаманд хянуулж бүртгүүлсэн	85
			Хууль зүйн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг	20	
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо	1500	
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа	65	
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал	25 сэдвээр 3500ш	
		Радио, телевизийн нэвтрүүлэг	-	
		Сонин хэвлэлээр сурталчилсан	-	
		Бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан /Facebook хуудсаар/	35 эрх зүйн актыг сурталчилсан	

МЭДЭЭ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ТЗАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН  
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ИЛТГЭХ ХУУДАС  
/2019 оны 4 дүгээр улирал/**

2019 оны 12 дугаар сарын 12

Өвт

Монгол Улсын хуулиуд, дагаж гарсан дүрэм, журмуудыг мөрдөж, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэрийг хяналтад авч, хэрэгжүүлэн, төсөвт байгууллагууд, албан хаагчид хамтран тайлант хугацаанд хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дараах ажлыг зохион байгуулж ажиллаа. Үүнд:

Нийтийн сонсголын тухай хууль 2015 оны 07 дугаар сарын 08-нд батлагдаж, 2016 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ЗДТГазар, “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан” ТББайгууллагын Өвөрхангай аймаг дахь салбартай хамтран 2019 оны 10 дугаар сарын 08-нд “2017, 2018 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд төсвийн хяналтын сонсгол” зохион байгуулалаа. Нийтийн сонсгол нийт 48 иргэн оролцож, 2017, 2018 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсвийн зарцуулалтын талаар санал, бодлоо илэрхийлж, бодитой мэдээлэлтэй болов. Нийтийн сонсгол нь төрийн бодлого, шийдвэр боловсруулах, хэлэлцэх, батлах, хэрэгжилтийг нь хянах бүхий л үйл ажиллагаанд иргэд оролцож, үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэрт саналаа тусгах боломж нөхцөлийг бүрдүүлсэн маш чухал арга хэмжээ юм. Энэ удаагийн нийтийн сонсголыг анх удаа зохион байгуулж байгаа бөгөөд цаашид жил бүр нийтэд тулгамдаж байгаа асуудлаар зохион байгуулж иргэдийн санал бодол, байр суурийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдэдээ тусган ажиллах шаардлагатай байгаа юм.



Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт үйлдэгдэн гарч байгаа хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сумын ГХУСАЗСЗөвлөл, ЗДТГазар, Сум дундын ой анги, Цагдаагийн хэсгээс санаачлан 2019 оны 10 дугаар сарын 25-нд Соёлын төвд сургалт, өдөрлөгт зохион байгуулав. Энэхүү өдөрлөгт Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар, Хархорин сум дахь Цагдаагийн хэлтэс, Хархорин сум дахь Прокурорын газар, ОХБЦГазрын хамгаалалтын захиргаа, БОАЖГазар, Мэргэжлийн хяналтын газар оролцож, иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хуулийн сургалт, сурталчилгаа, зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч ажиллаа. Сургалт, зөвлөгөөнд 400 гаруй иргэн хамрагдлаа.




Мөн Бат-Өлзий сумын ГХУСАЗСЗөвлөлийн шагналаар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд гишүүдийнхээ оролцоог тэгш хангаж, идэвх санаачлага гарган ажиллаж байгаа М.Сумъяацэцэг ахлагчтай "Сайхан хангай" нөхөрлөлийг, Мөн ойн модоо хамгаалж, байгаль орчинд ээлтэй, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад өөрийн хувь нэмрээ оруулж, аргал түлдэг 2 дугаар багийн иргэн Д.Даариймаа нарыг шагнаж урамшуулсан юм.





Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа "Зэвсэг -2019" нэгдсэн арга хэмжээний хүрээнд иргэний зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтыг Хархорин сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс, Бат-Өлзий сумын Цагдаагийн хэсэг хамтран сумын иргэдийн дунд зохион байгуулж, сургалтанд хамрагдсан 18 иргэнд гэрчилгээ гардуулж, сургалтаар олсон мэдлэгийг бататгах зорилгоор "АХА" тэмцээн зохион байгуулав.





Бат-Өлзий суманд 2019 оноос “Малын эрүүл мэнд төсөл” хэрэгжиж аймгийн хэмжээнд загвар сумаар сонгогдон малын эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний загвар нэгж бий болгох ажлыг хэрэгжүүлж байна. Малын гаралтай бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдлын баталгааг хангах, малын эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторын дарга, мэргэжилтнүүд, Аймгийн мал эмнэлгийн газрын төлөөлөл, мөн Аймгийн бэлчээр ашиглагчдын холбооны тэргүүн манай суманд хүрэлцэн ирж сумын удирдлагууд, мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд, мал эмнэлгийн нэгжийн малын эмч нар болон албан байгууллагын дарга эрхлэгч, нярав, тендер нийлүүлэгч аж ахуйн нэгжийн эзэд, малчид оролцсон сургалтыг амжилттай зохион байгуулалаа.

Сургалтын үр дүнд:

1. Иргэд, малчид хүнсний аюулгүй байдлын талаар цаг үеийн мэдээлэлтэй болсон.
2. Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд болон мал эмнэлгийн нэгжийн эмч нар шинэ программын мэдлэгтэй болсон.
3. Сургалтанд оролцсон иргэн, малчдад шинээр нэвтэрч байгаа программ болон малын халдварт, халдваргүй өвчний талаар гарын авлагаар хангагдсан.
4. Албан байгууллагын дарга, эрхлэгч нар тухайн байгууллагынхаа нярав, тендер нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн эзэдтэй хамт сургалтанд оролцсон давуу талтай. Сургалтанд нийт 85 иргэн хамрагдсан.



Багийн иргэдийн Нийтийн Хурлуудыг 2019 оны 10 дугаар сарын 14-с 11 дүгээр сарын 04-ны хооронд зохион байгуулж, ЗДТГазраас иргэдэд цаг үеийн мэдээ, мэдээллийг өгч, Иргэний бүртгэл, Нийгмийн халамж, Нийгмийн даатгал, Татвар, ХААТасаг, МЭТасаг, Байгаль орчин, Ойн анги, Цагдаагийн хэсэг, Эрүүл мэндийн төв, болон бусад албан байгууллагууд өөрсдийн салбар чиглэлийн хуулийн мэдээллийг бэлтгэн мэдээлэл хийж, иргэдэд сурталчилсан. Багийн хуралд оролцсон нийт 400-аад иргэнд гарын авлага тараасан.



2-р баг 2019.10.31





Сумын Засаг даргын Тамгын газраас “Иргэний андгай өргөх ёслол”-ийг 2019 оны 12-р сарын 03-нд сумын Соёлын төвд зохион байгуулж, 16 настнуудын төлөөлөл 16 сурагч Монгол Улсын иргэний үнэмлэхээ гардаж авлаа. Иргэний хуульд заасан эрх, үүргийг тайлбарлан таниулж, нийгмийг хөдөлгөх хүч болсон залууст юу юунаас илүү шинийг мэдэж суралцах үйлдээ нэн тэргүүнд анхаарч, цаг алдалгүй, залхуурахгүй биеэ дайчлан шаргуу хөдөлмөрлөхийг онцгойлон захиж хэллээ. Ёслолын үйл ажиллагаанд 130 гаруй сурагч



хүрэлцэн ирж, сурагчдын дунд АХА тэмцээн зохион байгуулж, эхний 3 байрыг шагнаж урамшуулав. Иргэний андгай өргөх ёслолыг ЗДТГ-ын Гэр бүл, хүүхэд, залуучууд хариуцсан мэргэжилтэн Г.Цэрэндулам, Улсын бүртгэгч Ө.Гөлгөө, сумын Хүүхдийн элч Г.Бямбагарав, НТБНэгжийн арга зүйч, багш Г.Дуламдорж нар хамтран зохион байгуулав.

Мөн ЗДТГ-ын Гэр бүл, хүүхэд, залуучууд хариуцсан мэргэжилтэн Г.Цэрэндулам сурагчдад Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.



“Татварын шинэчлэл-2” аян Бат-Өлзий суманд 2019 оны 11 дүгээр сарын 04-нд аймгийн Татварын хэлтэс, сумын татварын улсын байцаагч нар хамтран иргэдэд Татварын шинэчилсэн хуулиар сургалт зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, зөвлөгөө өгөв. Сургалт, мэдээлэлд 100 гаруй иргэн хамрагдсан.



ЕБСургууль анги удирдсан багш нарын дунд “Багш айлчлал аргачлал” сэдэвт сургалт зохион байгуулж 54 бүлгийн анги удирдсан багш нар хамрагдсан. Мөн сурагчдын эцэг, эхчүүдэд “Хүүхэд хамгааллын бодлого”, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар мэдээлэл, сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 200 гаруй эцэг, эх хамрагдсан.




2019 оны 11 дүгээр сарын 22-нд ЕБСургуулийн ахлах ангийн 138 хүүхдэд “Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай”, “Үе тэнгийнхэны дээрэлхэлтыг таслан зогсоох” чиглэлээр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас сургалт зохион байгуулсан.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Архидалтгүй Өвөрхангай хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэд хамтран “Яг одоо татгалзъя” аянд нэгдэж, 5 баг болон ажиллаж, архидан согтуурахтай тэмцэх, архины хор уршгийг сурталчилах нөлөөллийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж байна. “Яг одоо татгалзъя” аянд одоогийн байдлаар 3000 гаруй иргэнийг хамруулан ажиллаж байна.







### Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд:

Бат-Өлзий сумын Эрүүл мэндийн төвөөс аравдугаар сарыг “Ахмадын эрүүл мэндийг дэмжих сар” болгон 2019 оны 10 дугаар сарын 10-нд “Эрүүл байж урт наслая”, “Ахмад настны сэтгэл зүй” сэдвээр НЭМАжилтан Г.Ганчимэд 15 ахмад настанд, 2019 оны 10 дугаар сарын 29-нд “Тархинд цус харвалтаас урьдчилан сэргийлэх нь” сэдвээр ЭМТ-ийн дарга О.Отгонболд 21 ахмад настанд тус тус сургалт зохион байгуулсан.

ЭМТөвийн явуулын баг 2019 оны 10 дугаар сарын 18-нд “Бүрэгтий” багт ажиллаж нийт 44 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, үүнээс 21 ахмад настан хамрагдсан. Ахмадуудад хэвлийн ЭХО, цусны сахар, холестерин, элэгний В, С вирус үзсэн. В, С вирус илрээгүй, хэвлийн ЭХО-д өөрчлөлттэй хүн байхгүй. Нийт ахмадуудад АД ихсэлтээс хэрхэн урьчилан сэргийлэх талаар мэдээлэл өгсөн. Ахмадуудын дунд “Бид чадна” хөгжөөнт буухиа тэмцээн зохион байгуулж, тэмцээнд 4 багийн 24 ахмад, хөгжөөн дэмжигч нийт 55 ахмад оролцсон.

Эрүүл мэндийн төвийн 22 эмч, ажилтанд “Ажлын байрны стресс”, “Гарын эрүүл ахуй, Гэдэсний халдварын оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт” сэдвээр сургалт зохион байгуулсан.

ЭМТөв “Гар угаах дэлхийн өдөр”-өөр ЕБС-ийн дотуур байрын гал тогоо, нярав, Үдийн цайны нийт 11 тогооч нарт “Гарын эрүүл ахуй”, “Гэдэсний халдварт өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх” талаар сургалт хийж, “Аюулгүй хоол хүнсний 5 түлхүүр зарчим”-ыг сурталчилсан. Мөн дээрх сэдвээр дотуур байрын 66 сурагч, СӨББ-ын ахлах 2 бүлгийн 65 хүүхэд, ЕБС-ийн 1 ангийн 4 бүлгийн 110 хүүхдэд сургалт хийж, гар угаах орчинтой танилцаж зөвлөгөө өгсөн.

“Хараа хамгаалах дэлхийн өдөр”-өөр ЕБС-ийн 1 ангийн 135 хүүхдэд зурагт, гар утасны зохисгүй хэрэглээ нь хараанд хэрхэн нөлөөлж байгаа талаар энгийн ойлгомжтой хэлбэрээр сургалт зохион байгуулсан.

Мобайл технологийн урьдчилан сэргийлэх үзлэгээр ЭМТөв 2 багт ажиллаж ЭХО-33, хөхний хавдрын үзлэг-23, Умайн хүзүүний эсийн шинжилгээ-9, В,С вирус-33, МСС-25 хүнд үзлэг, шинжилгээ хийсэн.

Нийгмийн халамжийн Хүнсний эрхийн бичгийн хөнгөлөлтөнд хамрагддаг 85 иргэнд сумын нийгмийн ажилтан Н.Долгормаа, НЭМА Г.Ганчимэд нар хамтран “Элэгний хорт хавдар, хөх болон умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт зохион байгуулсан.

### Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх, сурталчилах хүрээнд

Бат-Өлзий сумын Соёлын төв "Соёлын өв хөгжлийн дархлаа сэдвийн хүрээнд" уламжлалт соёлыг түгээх, сурталчлах, дэлгэрүүлэх зорилгоор монголчуудын амьдрал ахуйдаа хэрэглэж, удам дамжин өвлөгдөн ирсэн биет өвийн "Монгол ахуй" үзэсгэлэн зохион байгуулалаа. Үзэсгэлэнд нийт 20 орчим иргэд 300 гаруй өвөөр оролцлоо. Уламжлалт аргаар гэрийн мод бэлтгэж байсан багаж хэрэгсэл, 5 дахь үедээ хэрэглэж байгаа модон тэвш, Цагаан хааны үеийн сэлэм, ширмэл ширдэг, эртний мөнгөн аяга, эртний эхнэр хүний толгойн гоёл, сампин, хөөрөг, монгол гутал, сур, дээл, хуу аяга, шавар ваар, гар аргаар бэлтгэсэн гэрийх хошлон, дайнд хэрэглэж байсан ярдаак буу, зууруул зэрэг ховор бүтээлүүдээрээ иргэд үзэсгэлэнд оролцсон. Мөн Монгол ардын уртын болон богино дуу, магтаал, исгэрээ, морин хуур зэрэг номеруудаар урлагийн тоглолт хийж биет бус өвийг сургалчиллаа.







Соёлын төвөөс төсөвт байгууллагын албан хаагчид болон иргэдэд “Дэлхийн өв- Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа болон соёлын өв гэж юу болох түний ангилал” сэдвээр сургалт зохион байгуулж, гарын авлага тараасан. Сургалтад нийт 50 албан хаагч, иргэд хамрагдсан.



Соёлын төвөөс Гэр бүлийн уншлага буюу хүүхдийн уншлаганд эцэг, эхийн оролцоо сэдвээр номын сангаар үйлчлүүлэгч хүүхэд багачууд болон уншигчдын эцэг, эхчүүдэд сургалт зохион байгуулсан. Сургалтыг Ерөнхий боловсролын сургууль болон Соёлын төвийн урлаг зааланд тус тус зохион байгуулж гарын авлага тараасан.



Үндэсний хөгжмийн ганцаарчилсан сургалтад нийт 10 сурагчид хамрагдаж байна. Морин хуур, ятга, ёочин зэрэг хөгжмөөр сургалтаа явуулж байна.



2019 оны 4 дүгээр улиралд Хууль, эрх зүйн сургалт 20 удаа зохин байгуулж, сургалтанд нийт 1500 гаруй хүн, эрх зүйн сурталчилгааг 65 удаа явуулж 25 сэдвээр 3500 гаруй гарын авлага, тараах материал иргэдэд тарааж ажилласан байна. Мөн олон нийтийн сүлжээгээр хууль, эрх зүйн мэдээллийг Инфографикаар түгээн ажилласан.

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ЗДТГ-ЫН ТЗАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД



